



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 454 дүгээр тогтоолоор батлагдсан заавар, дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлан, түүний тодруулгад нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 454 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа явуулах этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар”-г доор дурьдсан агуулгатай дараах 1 дүгээр зүйлийн 1.9, 1.10 дахь заалтуудыг тус тус нэмсүгэй:

1/ “1.9. Брокерийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь Хороонд бүртгүүлсний дагуу гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд хөрөнгийн бүртгэлийн програм хангамжийн тусламжтайгаар харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан харилцагч бүрээр тусгайлан, нэр төрлөөр нь балансын гадуур дэлгэрэнгүй бүртгэнэ.;

1.10. Харилцагчийн гадаад улсын үнэт цаасны зах зээлээс үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгө, худалдан авсан үнэт цаас, түүнтэй холбоотой орлогыг тайлангийн тодруулгын “Балансын гадуурх бүртгэлийн тодруулга” хэсэгт тусгана.”

2. “Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлан, түүний тодруулга”-д доор дурдсан агуулгатай дараах 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.3 дахь заалтуудыг тус тус нэмсүгэй:

1/ “26. БАЛАНСЫН ГАДУУРХ БҮРТГЭЛИЙН ТОДРУУЛГА

26.1. Харилцагчийн мөнгө хөрөнгө:

№	Мөнгөн хөрөнгийн зүйлс	Эхний үлдэгдэл /төг/	Эцсийн үлдэгдэл /төг/
1	Харилцах данс /MNT/		
2	Харилцах данс /USD/		
3	Харилцах данс /CAD/		
4	Харилцах данс /HKD/		
5	Харилцах данс /AUD/		
6			
7	Нийт дүн /төг/		

000120

26.2. Харилцагчийн өмнөөс худалдан авсан үнэт цаас:

№	Үзүүлэлт	Харилцагчийн эзэмшиж буй үнэт цаас /төгрөгөөр/			Нийт дүн
		Хувьцаа	Бонд	Үүсмэл үнэт цаас	
1	Эхний үлдэгдэл /өртгөөр/				
2	Нэмэгдсэн дүн				
3	Хасагдсан дүн (-)				
4	Эцсийн үлдэгдэл /өртгөөр/				
5	Үнэт цаасны бууралтын гарз (-)				
6	Үнэт цаасны өсөлтийн олз				
7	Дансны цэвэр дүн				

26.3. Бусад балансын гадуурх өр төлбөр

.....”

3. Заавар, дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлан, түүний тодруулгад нэмэлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Хүндэтгэсэн
Хүндэтгэгч
Хүндэтгэгч